ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2025/143/НА-СТА-ТШЗ


Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Үндраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -гэрээт аудитор: Б.Цэрэндэжид

Утас: 99812811

Цахим хаяг: tserendejid1109@gmail.com


Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
   2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
   2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
   2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
   2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
   2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 8
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан ........ 13
   4.1 Ерөнхий зүйл ........ 13
   4.2 Материаллаг байдал ........ 14
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт ........ 14
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 14
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 16
5. Аудитын илрүүлэлт ........ 16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.11 № 86

танай ________ -ны № ________ -т

ЭРДЭНЭХАЙРХАН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Г.СОСОРБУРАМ-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 11 багш хамрагдсанаас 10 багш амжилттай сайн үнэлгээ, 2 багш 1 дүгээр түвшинд, 5 багш 2 дугаар түвшинд, 1 багш 3 дугаар түвшинд, 3 багш 4 дүгээр түвшинд хамрагджээ. Үүний үр дүнд байгууллагын үнэлгээгээр сүүлийн 3 жил 2 дугаар индексээр үнэлэгдэж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 226 нэр төрлийн 287,694.4 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгөтэй, дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас уралдаан тэмцээнд оролцсон сурагчдын хоолны зардалд 1,876.4 мянган төгрөг, гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагддаг ТҮБД-ээр цалинждаг сургалтын менежер, нийгмийн ажилтан, байрын багш, насан туршийн боловсролын багшид захирлын тушаалаар 3,300.1 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал, батлагдаагүй орон тоонд албан тушаал хавсарсны нэмэгдэл 488.8 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсрол сургууль нь төсвийн хөрөнгөөр 149.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 33,312.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусгажээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**2024 оны 12 дугаар сарын 31** /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 142,110,741.13 | 320,036,824.25 |
| 2 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 36,725,016.6 | 210,999,588.32 |
| 8 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 36,725,016.6 | 210,999,588.32 |
| 16 | Гадаад валютаар | | |
| 17 | Төрийн сангийн харилцах | 36,725,016.6 | 210,999,588.32 |
| 27 | АВЛАГА | | |
| 28 | Ажиллагсадтай холбогдсон авлага | | |
| 29 | Төлбөртэй үйлчилгээний авлага | | |
| 34 | Бусад авлага | | |
| 35 | Байгууллагаас авах авлага | | |
| 60 | БАРАА МАТЕРИАЛ | 105,385,724.53 | 109,037235.93 |
| 61 | Түүхий эд материал | 63,132,242.85 | 63,091,242.85 |
| 62 | Тусгай зориулалттай материал | 62,962,242.85 | 62,923,242.85 |
| 63 | Эм боох материал | 170,000.00 | 168,000.00 |
| 66 | Хангамжийн материал | 42,253,481.68 | 45,945,993.08 |
| 67 | Бичиг хэргийн материал | 10,948,437.4 | 15,733,344.8 |
| 68 | Аж ахуйн материал | 15,087,403.28 | 15,901,703.28 |
| 70 | Түлш шатах тослох материал | 1,300,000.00 | 3,000,000.00 |
| 71 | Барилгын засварын материал | | |
| 72 | Хүнсний материал | 3,431,100.00 | 5,172,050.00 |
| 73 | Бусад хангамжийн материал | 5,347,646.00 | 6,138,895.00 |
| 86 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 788,856,774.83 | 912,437,833.75 |
| 106 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 788,856,774.83 | 912,437,833.75 |
| 108 | Биет хөрөнгө | 730,228,774.83 | 854,139,833,75 |
| 109 | Барилга, байгууламж | 688,374,671.93 | 688,374,671.93 |
| 110 | Хуримтлагдсан элэгдэл | -146,671,190.00 | -168,403,628.00 |
| 111 | Авто тээврийн хэрэгсэл | 27,335,000.00 | 27,335,000.00 |
| 112 | Хуримтлагдсан элэгдэл | -27,064,166.35 | -27,335,000.00 |
| 113 | Машин, тоног төхөөрөмж | 257,469,594.22 | 439,985,874.22 |
| 114 | Хуримтлагдсан элэгдэл | -168,393,227.77 | -192,018,116,.45 |
| 115 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 99,284,291.6 | 99,284,291.6 |
| 116 | Хуримтлагдсан элэгдэл | -73,435,682.57 | -82,064,663.72 |
| 122 | Бусад үндсэн хөрөнгө | 79,177,870.75 | 79,177,870.75 |
| 123 | Хуримтлагдсан элэгдэл | -45,220,020.3 | -49,568,099.9 |
| 124 | Ном | 39,371,633.32 | 39,371,633.32 |
| 126 | Биет бус хөрөнгө | 58,628,000.00 | 58,628,000.00 |
| 127 | Програм хангамж | 2,030,000.00 | 2,030,000.00 |
| 128 | Хасагдуулга | -1,370,000.00 | -1,700,000.00 |
| 129 | Бусад биет бус хөрөнгө | 57,968,000.00 | 57,968,000.00 |
| 137 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 930,967,515.96 | 1,232,474,658.00 |
| 138 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | | 94.096.750.00 |
| 139 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 94.096.750.00 |
| 164 | Өглөг | | 94.096.750.00 |
| 165 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | | |
| 170 | Бусад өглөг | | 94.096.750.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 171 | Байгууллагад төлөх өглөг | | 94.096.750.00 |
| 172 | Хувь хүмүст төлөх өглөг | | |
| 214 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 930,967,515.96 | 1,138,377,908.00 |
| 215 | Засгийн газрын хувь оролцоо | 930,967,515.96 | 1,138,377,908.00 |
| 216 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 559,715,955.65 | 559,715,955.65 |
| 217 | Өмч: -Төрийн өмч | 559,715,955.65 | 559,715,955.65 |
| 223 | Хуримтлагдсан үр дүн | -12,632,264.32 | 194,778,127.72 |
| 224 | Өмнөх үеийн үр дүн | -12,632,264.32 | -12,632,264.32 |
| 225 | Тайлант үеийн үр дүн | | 207,410,392.04 |
| 227 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 383,883,824.63 | 383,883,824.63 |
| 231 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 930,967,515.96 | 1,232,474,658.00 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 905,419,234.29 | 1,408,957,537.4 |
| 76 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 21,455,950.29 | 38,515,837.4 |
| 77 | Нийтлэг татварын бус орлого | 21,455,950.29 | 38,515,837.4 |
| 81 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 1,613,500.00 | 1,067,100.00 |
| 82 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 118,000.00 | 1,067,100.00 |
| 83 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,495,500.00 | |
| 84 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- үндсэн хөрөнгө | 19,504,035.29 | 33,312,230.00 |
| 85 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал | 338,415.00 | 4,136,507.4 |
| | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 883,963,284.00 | 1,370,441,700.00 |
| 143 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 767,184,000.00 | 1,238,844,400.00 |
| 145 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт орон нутаг | 116,763,300.000 | 131,597,300.00 |
| 146 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 15,984.00 | |
| 147 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 906,789,795.86 | 1,201,547,145.36 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 906,789,795.86 | 1,201,547,145.36 |
| 149 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 878,721,325.86 | 1,171,316,082.98 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 567,720,399.00 | 804,230,308.00 |
| 151 | Цалин | 377,096,682.00 | 446,966,374.03 |
| 152 | Нэмэгдэл цалин | 151,312,951.00 | 280,819,702.00 |
| 153 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 154 | Урамшуулал | 39,310,766.00 | 76,444,231.97 |
| 157 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 67,957,081.00 | 100,426,967.97 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 44,693,381.00 | 66,093,867.97 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 5,815,700.00 | 8,583,400.00 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4,652,700.00 | 4,291,600.00 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1,163,000.00 | 4,291,600.00 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 11,632,300.00 | 17,166,500.00 |
| 164 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 112,763,300.00 | 122,849,337.62 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 4,538,900.00 | 6,734,937.62 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 108,224,400.00 | 116,114,400.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | | |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 13,617,660.00 | 18,389,700.00 |
| 171 | Бичиг хэргийн материал | 4,181,780.00 | 3,908,700.00 |
| 172 | Тээвэр, шатахууны зардал | 3,926,940.00 | 4;182,100.00 |
| 00173 | Шуудан холбоо интернетийн төлбөр | | |

| | | | |
|---|---|---|---|
| 175 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | | |
| 176 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 5,508,940 | 10,298,900.00 |
| 178 | Бараа материал актасны зардал | | |
| 181 | Нормативт зардал | 45,851,584.00 | 51,369,646.00 |
| 182 | Эм | 220,000.00 | 2,000.00 |
| 183 | Хоол | 45,631,584.00 | 51,367,646.00 |
| 184 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,040,000.00 | 3,431,100.00 |
| 188 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | | |
| 189 | Урсгал засвар | 2,040,000.00 | 3,431,100.00 |
| 190 | Томилолт, зочны зардал | | |
| 192 | Дотоод томилолтын зардал | | |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 2,585,920.00 | 4,681,702.31 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 190,920.00 | 928,600.00 |
| 196 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | | |
| 198 | Тээврийн хэрэгслийн татвар | | |
| 200 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 2,395,000.00 | 3,753,102.31 |
| 201 | Газрын төлбөр | | |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 66,185,381.86 | 65,937,321.08 |
| 212 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 58,627,001.86 | 58,935,221.08 |
| 224 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 28,068,470.00 | 30,231,062.38 |
| 228 | Бусад урсгал шилжүүлэг | 28,068,470.00 | 27,183,100.00 |
| 236 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 7,538,600.00 | 7,615,600.00 |
| 237 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж | 20,529,870.00 | 19,567,500.00 |
| 238 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 3,047,962.38 |
| 269 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | -1,370,561.57 | 207,410,392.04 |
| 277 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | | |
| 278 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | |
| 288 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V) | | |
| 289 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | -1,370,561.57 | 207,410,392.04 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 77 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 885,576,784.00 | 1,371,508,800.00 |
| 78 | Нийтлэг татварын бус орлого | 1,613,500.00 | 1,067,100.00 |
| 82 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 1,613,500.00 | 1,067,100.00 |
| 83 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 118,000.00 | 1,067,100.00 |
| 84 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,494,500.00 | 1,067,100.00 |
| 110 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 883,963,284.00 | 1,370,441,700.00 |
| 143 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 767,184,000.00 | 1,238,844,400.00 |
| 144 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт орон нутаг | 116,763,300.000 | 131,597,300.00 |
| 145 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 15,984.00 | |
| 147 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 846,070,200.00 | 1,142,126,928.28 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 846,070,200.00 | 1,142,126,928.28 |
| 149 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 817,471,600.00 | 1,110,408,465.9 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 565,726,772.00 | 804,230,308.00 |
| 151 | Үндсэн цалин | 375,103,055.00 | 446,966,374.03 |
| 152 | Нэмэгдэл | 151,312,951.00 | 280,819,702.00 |
| 153 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 154 | Үр дүнгийн урамшуулал | 39,310,766.00 | 76,444,231.97 |

| | | | |
|---|---|---|---|
| 157 | Ажил олгочоос нийгтийн даатталд төлөх шимтгэл | 69,950,708.00 | 100,426,967.97 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 46,687,008.00 | 66,093,867.97 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 5,815,700.00 | 8,583,400.00 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4,652,700.00 | 4,291,600.00 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1,163,000.00 | 4,291,600.00 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 11,632,300.00 | 17,166,500.00 |
| 164 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 112,763,300.00 | 124,549,337.62 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 4,538,900.00 | 6,734,937.62 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 108,224,400.00 | 117,814,400.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | | |
| 181 | Нормативт зардал | 42,159,400.00 | 49,704,500.00 |
| 182 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 183 | Хоол, хүнс | | |
| 184 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 186 | Багаж техник хэрэгсэл | | |
| 188 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | | |
| 189 | Урсгал засвар | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 190 | Томилолт, зочны зардал | | |
| 192 | Дотоод албан томилолт | | |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,613,900.00 | 4,681,702.31 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 1,128,900.00 | 928,600.00 |
| 196 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | |
| 198 | Тээврийн хэрэгслийн татвар | | |
| 200 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,395,000.00 | 3,753102.31 |
| 201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,257,520.00 | 22,815,500.00 |
| 202 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,261,340.00 | 18,126,490.00 |
| 203 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,996,080.00 | 4,689,010.00 |
| 221 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 28,598,600.00 | 28,670,500.00 |
| 225 | Бусад урсгал шилжүүлэг | 28,598,600.00 | 21,054,900.00 |
| 233 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 7,538,600.00 | 7,615,600.00 |
| 234 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 3,047,962.38 |
| 251 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 39,506,584.00 | 229,381,871.72 |
| 252 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 262 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | | |
| 263 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | |
| 264 | Дотоод эх үүсвэрээр | 10,195,000.00 | 55,107,300.00 |
| 276 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,195,000.00 | 55,107,300.00 |
| 279 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -10,195,000.00 | -55,107,300.00 |
| 280 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 304 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 29,311,584.00 | 174,2744,571.72 |
| 305 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 36,725,16.60 |
| 306 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 210,999,588.32 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 559,715,955.65 | 383,883,824.63 | -12,632,264.32 | 930,967,515.96 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 559,715,955.65 | 383,883,824.63 | -12,632,264.32 | 930,967,515.96 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 204,410,392.04 | 204,410,392.04 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | | | 207,410,392.04 | 207,410,392.04 |
| 18 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 559,715,955.65 | 383,883,824.63 | 194,778,127.72 | 1,138,377,908.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 36,725,016.6 |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,408,233,500.00 | 1,191,138,303.52 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 1,408,233,500.00 | 1,139,078,965.90 |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 1,377,979,100.00 | 1,110408,465.9 |
| 5 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 967,905,000.00 | 804,230,308.00 |
| 6 | Үндсэн цалин | 676,113,000.00 | 446,966,374.03 |
| 7 | Нэмэгдэл | 257,066,000.00 | 280,819,702.00 |
| 8 | Унаа, болон бусад нөхөн олговор | | |
| 9 | Урамшуулал | 34,726,000.00 | 76,444,231.97 |
| 11 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 120,988,100.00 | 100,426,967.97 |
| 12 | Тэтгэврийн даатгал | 82,272,100.00 | 66,093,867.97 |
| 13 | Тэтгэмжийн даатгал | 9,679,100.00 | 8,583,400.00 |
| 14 | ҮОМШӨ ний даатгал | 4,839,500.00 | 4,291,600.00 |
| 15 | Ажилгүйдлийн даатгал | 4,839,500.00 | 4,291,600.00 |
| 16 | Эрүүл мэндийн даатгал | 19,358,000.00 | 17,166,500.00 |
| 17 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 127,597,300.00 | 124,549,337.62 |
| 18 | Гэрэл цахилгаан | 11,146,700.00 | 6,734,937.62 |
| 19 | Түлш, халаалт | 115,493,400.00 | 117,814,400.00 |
| 20 | Цэвэр, бохир ус | 957,200.00 | |
| 30 | Нормативт зардал | 64,373,200.00 | 49,704,650.00 |
| 31 | Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл | | |
| 32 | Хоол, хүнс | 64,373,200.00 | 49,704,650.00 |
| 33 | Нормын хувцас зөөлөн эдлэл | | |
| 34 | Эд хогшил худалдан авах | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 35 | Багаж, техник, хэрэгсэл | | |
| 37 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | | |
| 38 | Урсгал засвар | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 39 | Томилолт, зочны зардал | | |
| 41 | Дотоод албан томилолт | | |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 9,486,000.00 | 4,681,702.31 |
| 44 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 928,600.00 |
| 48 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | | |
| 49 | Мэдээллийн технологийн зардал | 9,486,000.00 | 3,753,102.31 |
| 50 | Бараа үйлчилгээний бусад зардал | 83,629,500.00 | 77,922,800.00 |
| 51 | Бараа үйлчилгээний бусад зардал | 78,900,400.00 | 73,233,790.00 |
| 53 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,729,100.00 | 4,689,010.00 |
| 66 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 30,254,400.00 | 28,670,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 70 | Бусад урсгал шилжүүлэг | 30,254,400.00 | 28,670,500.00 |
| 78 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 7,615,600.00 | 7,615,600.00 |
| 79 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| 80 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж ,урамшуулал | 22,638,800.00 | 21,054,900.00 |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | |
| 106 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,238,844,400.00 | 1,238,844,400.00 |
| 109 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт орон нутаг | 131,597,300.00 | 131,597,300.00 |
| 110 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | | 1,067,100.00 |
| 111 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 36,725,016.60 |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 210,999,588.32 |
| 129 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 1 | |
| 130 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 31 | 31 |
| 134 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 135 | Гүйцэтгэх ажилтан | 20 | 20 |
| 136 | Үйлчлэх ажилтан | 10 | 10 |
| 138 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | - | - |
| 148 | ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО | - | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэл:***

- *Ерөнхий боловсрол олгох*

***Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн зорилго:*** Эх хэлээ дээдлэн унших,бичих,суралцах чадвараа хөгжүүлсэн, эрүүл зөв хандлагатай хамт олныг төлөвшүүлнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.6 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Ерөнхий боловсролын сургуулийн*** *үйл ажиллагаанд мөрддөг хууль:*

1. Боловсролын ерөнхий хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд орсон өөрчлөлт:

2024 оны 03 сарын 27-ны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалйн цалингийн хэмжээг шинэчлэн тотоосон, Боловсролын ерөнхий хууль 2024 оны 07-р сарын 07-нд батлагдсан. Засгийн газрын 2024 оны 08 сарын 28-ны 53 дугаар тогтоолоор “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр” шинэчлэгдэн батлагдсан, Сангийн Сайдын 2024 оны 04 сарын 01-ний А/52 тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсан.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 1,3 "Аж ахуйн нэгж байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна гэсний дагуу байгууллагын дотоод хяналтын комиссыг 2024 оны 09 сарын 02-ны А/12 тушаалаар шинэчлэн 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Журмаа шинэчлэн боловсруулж улирал бүр төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тайлагнаж ажилладаг

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Сургуулийн захирал, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос мянган төгрөгөөр 301,507.1 буюу 30 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1.** Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Банкинд байгаа мөнгө | 36,725.0 | 210,999.6 | 174,274.6 |
| Бараа материал | 105,385.7 | 109,037.2 | 3,651.5 |
| Үндсэн хөрөнгө | 788,856.8 | 912,437.8 | 123,581.0 |
| **Нийт хөрөнгө** | **930,967.5** | **1,229,474.6** | **298,507.1** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 930,967.5 | **1,229,474.6** | **298,507.1** |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **930,967.5** | **1,229,474.6** | **298,507.1** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд**

Бараа материалын эхний үлдэгдэл 105,385.7 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 98,822.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч мөн 4,136.5 мянган төгрөгний хөрөнгө хандиваар авч , 99,307.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 109,037.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,651.5 мянган төгрөгөөр өссөн байна.
Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 149,204.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч мөн хөрөнгө оруулалтаар 33,312.2 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж жилийн эцэст 1,433,527.3 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 521,089.5 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 298,507.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,238,844.4 мянган төгрөг, нийт зарлагыг 1,197,234.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл боловсролын яамнаас нэмэлт тодотгол хийсэн .

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,370,441.7 мянган төгрөгнөөс орон нутгийн төсвөөс 131,597.3 мянган төгрөгийн санхүүжилт авч 3,048.0 төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,197,234.2 мянган төгрөг буюу 87.3 хувьтай байна. Энэ нь цалин, ндш, хоолны 210,999.6 төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | | | | |
| **71802** | **Ерөнхий боловсрол** | | | | |
| 80233 | Хүүхэд хамгаалал | 1,286.00 | 1,286.00 | | 100% |
| 80312 | Сургалт семинар | 888.5 | 888.5 | | 100% |
| 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 1,171.7 | 809.0 | 362.7 | 69.1% |
| 81827 | Бичиг үсгийн боловсрол олгох | 2,575.3 | 2,575.1 | 0.2 | 100% |
| 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 1,211.00 | 1,211.00 | | 100% |
| 81801 | Үдийн цай | 22,638.8 | 21,054.9 | 1,583.9 | 93% |
| 80109 | ТЗШ байгууллагуудын тогтмол зардал | 131,597.3 | 131,597.3 | 0 | 100% |
| 81806 | Дотуур байрын үйлчилгээ | 201,634.2 | 159,388.2 | 42,246.0 | 79.0% |
| 81816 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 53,567.3 | 53,567.3 | | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 81823 | Боловсролын байгууллагын багш ажилтаны мэргэжил дээшлүүлэх | 3,515.0 | 200.0 | 3,315.00 | 5,7% |
| 81834 | Боловсролын стандарт сургалтын орчин | 936,058.7 | 781,043.0 | 155,015.7 | 77.8% |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 48,674.4 | 41,906.9 | 6,767.5 | 86.1% |
| 81848 | Сурах бичгийн түрээс | 1,448.8 | 928.6 | 520.2 | 64% |
| 81875 | Сургуулийн нэмэлт хөтөлбөр | 1,966.8 | 778.4 | 1,188.4 | 39.5% |
| **НИЙТ** | | **1,408,233.8** | **1,197,234.2** | **210,999.6** | **85.02%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулж Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 70,759.5 мянган төгрөгөөр, шууд худалдан авалтыг 159,082.5 мянган төгрөгөөр хийсэн байна.

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Эрдэнэхайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёомбо аудит ХХК"-ны гэрээт аудитор Б.Цэрэндэжид гүйцэтгэж, анхан шатны хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Эрдэнэхайрхан сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1,408,957.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 28,217.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 22,543.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Эрдэнэхайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, албан шаардлага өгөгдөөгүй.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,665.3 мянган төгрөгийн алдаа илэрч, 3,788.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

***Залруулсан алдаа:*** *Залруулсан алдаа байхгүй*

### 5.1 Төлбөрийн акт:

***<u>Илэрсэн алдаа:</u>*** Албан хаагчдад үр дүнгийн урамшуулал 3,300.1 мянган төгрөг, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 488.8 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон

***<u>Шийдвэрлэсэн нь:</u>*** Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна", 2.5-д "Энэ журмын 2.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно" гэж заасныг тус тус зөрчсөнд 3,788.9 мянган төгрөгийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

### 5.3 Зөвлөмж:

***<u>Илэрсэн алдаа:</u>*** Дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас уралдаан тэмцээнд оролцсон хүүхдүүдийн хоолонд олгосон

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"ыг, батлагдсан төсвийн дагуу эдийн засгийн ангилалаар зардал гаргах, хууль, журмыг мөрдөж ажиллах, хяналтыг хэрэгжүүлэх

***<u>Илэрсэн алдаа:</u>*** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 226 төрлийн 1696 ширхэг 287,694.4 мянган төгрөгийн хөрөнгө элэгдээрээ анхны өртгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. . Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтлөж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***<u>Өгсөн зөвлөмж:</u>*** Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул **"Өөрчлөлтгүй"** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнэлгээ: Төлбөрийн акт | | Үнэлгээ: Албан шаардлага | | Үнэлгээ: Зөвлөмж | | Үнэлгээ: Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Үнэлгээ: Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагддаг ТҮБД-ээр цалинждаг сургалтын менежер,нийгмийн ажилтан,байрын багш,насан туршийн боловсролын багш нарт захирлын тушаалаар үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон | 1 | 3,300.1 | 1 | 3,300.1 | | | | | | | | |
| Батлагдсан орон тоогүй албан тушаалд хавсарсны нэмэгдэл олгосон | 1 | 488.8 | 1 | 488.8 | | | | | | | | |
| Дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас уралдаан тэмцээнд оролцсон хүүхдүүдийн хоолонд олгосон | 1 | 1,876.4 | | | | | 1 | 1,876.4 | | | | |
| Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 0 үлдэгдэлтэй байгаа 226 нэр төрлийн 1696 ширхэг 287,694,427.60 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг сунгах | 1 | | | | | | | | | | | |
| **Дүн** | | **5,665.3** | | **3,788.9** | | | | **1,876.4** | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-01-25

**БОЛОВСРУУЛСАН:**

"ХААН СОЁМО АУДИТ" ХХК ГЭРЭЭТ АУДИТОР Б.ЦЭРЭНДЭЖИД

Огноо: 2025-01-25